

Монгол улс дахь гэр бүлийн хүчирхийлэл, түүний төлөв байдал

*Өрх гэр доройтвол төр улс мөхөх тул
... муу зүйлийг чанга сэрэмжлүүлсүгэй.¹*

Монголчуудын эртнээс уламжлан ирсэн гэр бүлийн харилцааны соёл нь гэр бүлээ дээдэлж, ханийн ёсыг эрхэмлэх “*салиггүй ханьдаа мартагдашгүй муу үгийг бүү хэл*” хэмээн сургаал үгээр илэрхийлдэгдэж иржээ.

Гэр бүл гэдэг нь хүмүүсийн ердийн харилцаанаас илүү дотно, өөриймсөг харилцаа үүсгэдэг ч өмчлөх сэтгэхүйгээр гэр бүлийн гишүүдийн хуулиар хамгаалагдсан эрх чөлөөг зөрчих талбар, боломж биш юм.

Гэр бүлийн хүчирхийлэл нь дан ганц хувь хүнээс үүдэлтэй гэвэл өрөөсгөл болно. Дэлхий нийт даяарчлагдаж байгаа нь нэг талаас улс орнуудын хөгжил дэвшилд эерэг үр дагавар бүхий шинэ шинэ боломжуудыг нээсэн сайн талтай ч нөгөө талаас гэр бүлийн харилцааны үнэт зүйлс, сонгодог заншлууд орхигдон гээдэж энэ хирээр гэр бүлийн харилцаа тогтворгүй болох, эвдрэх, салах, хүч хэрэглэх гэмт явдал ихсэх үндсэн нэг шалтгаан болж байна.

Цагдаагийн ерөнхий газрын /цаашид ЦЕГ гэх/ Мэдээлэл, судалгааны төвөөс жил бүр гаргадаг “Монгол улс дахь гэмт хэрэг, захиргааны зөрчлийн байдал” судалгаа нь 2010 оноос өмнө гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргийн судалгааг тусгайлан гаргадаггүй байсан ба харин 2010 онд ЦЕГ, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хооронд байгуулсан “Криминологи судалгааны чиглэлээр хамтран ажиллах санамж бичиг”-ийн хүрээнд боловсруулсан төлөвлөгөөний дагуу тус төвийн ажилтнууд 2003-2010 оны гэмт хэргийн статистик мэдээлэлд Эрүүгийн хуулийн 14 дүгээр бүлэгт заасан зарим төрлийн буюу “Хүүхэд гэр бүл, ёс суртахууны эсрэг гэмт хэрэг”-ийн шалтгаан нөхцөл” судалгааг хийж, цаашдын хандлага төлөвийг тодорхойлсон байна.²

Судалгааны хүрээг харахад голчлон хүүхэдтэй зүй бусаар харьцах, хүчирхийлэх, бэлгийн болон хөдөлмөрийн мөлжлөгөд ашиглах явдлыг хамруулсан байна. Энэхүү судалгаагаар “Хүүхэд гэр бүл, ёс суртахууны эсрэг гэмт хэрэг” нуугдмал байсаар байгаа төдийгүй 5 жилийн хэтийн төлөв байдлыг үзэхэд энэ төрлийн гэмт хэрэг түгээмэл, нуугдмал түвшинд гарсаар байх төдийгүй хэргийн гаралт өсч, зохион байгуулалтанд шилжих хандлагатай байна³ гэж онцлон тэмдэглэжээ.

2011 оноос ЦЕГ-н Мэдээлэл, судалгааны төв ньгэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн судалгааг тусгайлан судалдаг болсон ба энэхүү судалгаанаас харахад гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотойгоор:

- 2011 онд 420,
- 2012 онд 534,

¹Их засаг хууль. 5 дугаар зүйл. Гэр бүлийг засах цааз.

²Монгол улс дахь 2010 оны гэмт хэргийн байдал, шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам. ЦЕГ. Мэдээлэл, судалгааны төв.УБ., 2011. 157 дахь тал

³ЦЕГ.Мэдээлэл судалгааны төв.

- 2013 онд 418,
- 2014 онд 1076 гэмт хэрэг⁴ сүүлийн 4 жилд нийтдээ 2448 гэмт хэрэг үйлдэгдэж, 2463 хүн янз бүрийн түвшний гэмтэл авсан, 53 хүн нас барсан, гэмт хэргийн улмаас 877.8 сая төгрөгийн эд хөрөнгийн хохирол учирчээ.

Эдгээр гэмт хэргийн хохирогчдийн **90 %** нь эмэгтэйчүүд байгаа ба нийт хохирогчдийн 62.5 % нь бие мах бодийн, 20 % нь сэтгэл санааны, 1.6 % нь бэлгийн, 0.8 % нь эдийн засгийн хүчирхийлэлд өртсөн байгаа бол ихэнх хүүхдийн хүчирхийлэлд өртсөн, гэмт хэрэг үйлдсэн шалтгаан нь гэр бүл дэх хүчирхийллэс гадна эцэг эхийн халамж анхаарал дутнаас болжээ. Өөрөөр хэлбэл эцэг эх нь амьжиргаагаа залгуулах үүднээс ажлын байран дээрээ ихэнх цагаа өнгөрүүлж байна гэсэн үг.

Энэ тоо баримт гэр бүлийн хүчирхийлэл нь манай нийгэмд бодитойгоор оршин хувь хүн, нийгмийн тодорхой хэсгийн /эмэгтэйчүүд, хүүхдүүдийн/ эрх ашгийг зөрчиж байна гэдгийг харуулж байгаа юм.

Хүчирхийлэлд өртөгчдийн хүрээг судлан үзэхэд эцэг, эх, эхнэр, нөхөр, төрсөн, дагавар, үрчилж авсан хүүхэд, ах дүүс, бэр хүргэн гэхчилэн бүхий л цусан болон төрөл саданг хамарсан байгаа нь гэр бүлийн хүчирхийлэл нь хүний аливаа эрх, эрх чөлөөг зөрчиж, хүний эрхэд халдсан гэмт хэрэг мөн болохыг батлан харуулж байна.

Зөвхөн Улаанбаатар хотод ахуйн хүрээнд үйлдэгдсэн гэмт хэргийн хүчирхийлэгчдийн 67 % нь хувь нь салсан эсхүл одоо сууж буй нөхөр нь, 3.4 нь хамтран амьдрагч нь, 7.1 % нь үерхдэг найз нь, 5 % нь эцэг нь эзэлдэг төдийгүй үр хүүхэд нь эцэг эх, хадамаа хүчирхийлэх гэмт хэргүүд ч цөөнгүй байгаа юм.

Хүчирхийлэл үйлдэгчдийн насны байдлыг судалж үзэхэд ухаан сууж төлөвших ёстой 25-45 насныхан дийлэнх хувийг эзэлж байгаа ба боловсролын хувьд 25.6 % нь дээд, 42.5 %-ийг бүрэн дунд боловсролтой этгээдүүд үйлдсэн байгаа ч 50 % нь эрхэлсэн ажилгүй байна.

2014 онд үйлдэгдсэн энэ төрлийн гэмт хэргийг өмнөх жилийнхтэй харьцуулахад **2.6 дахин өссөн** байгаа нь гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэрэг жилээс жилд өсч байна гэдгийг харуулж байна.

2015 оны эхний 2 сард үйлдэгдсэн гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэрэг 180 үйлдсэн ба тэдгээрийн 57.2 % нь нийслэлд, 42.2 хувь нь аймгуудад үйлдэгджээ. Хэргийн өнгөөр авч үзвэл:

- 73.9 % нь хөнгөн,
- 16.7 % нь хүндэвтэр,
- 7.8 % хүнд,
- 1.6 % нь онц хүнд ангиллийн гэмт хэрэг эзэлж байгаа ба гэмт хэргийн улмаас 178 иргэн хохирсны 88.7 % нь эмэгтэйчүүд, 4 хүн нас барж, 153 хүн ямар нэг хэлбэрээр гэмтсэн, 66.5 сая төгрөгийн эд хөрөнгийн хохирол иргэдэд учирчээ.

Хүчирхийлэлд өртсөн хугацааг авч үзэхэд доод тал нь 1 жил, дээд тал нь 8-аас дээш жил байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой дээрхи гэмт хэргүүдийг 171 хүн үйлдсэний:

⁴ ЦЕГ. Мэдээлэл, технологийн төвийн мэдээ

- 1.2 % нь боловсролгүй,
- 5.3 % нь бага боловсролтой,
- 19.3 % нь бүрэн бус дунд,
- 42.1 % нь бүрэн дунд,
- 6.8 % нь тусгай дунд /мэргэжлийн/,
- 25.7 % нь дээд боловсролтой хүн үйлдсэн. Эдгээрийн 49 % нь ажилгүй, 44 %

нь согтуугаар гэмт хэргийг үйлджээ.

Архи уудаг, тарчиг ядуу амьдралтай, боловсролгүй хүн хүчирхийлэл үйлддэг гэдэг нь өрөөсгөл бөгөөд харин амьжиргааны түвшин дээгүүр, өндөр боловсролтой хүн ч гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг гэдгийг дээрхи тоо баримт нотлон харуулж байна. Архидалт, тарчиг амьдрал нь гэр бүлийн хүчирхийллийн суурь шалтгаан биш, харин түүнийг дэвэргэх хүчин зүйл юм.

Хүчирхийлэл үйлдэгчдийн насны байдлыг авч үзэхэд:

- 14-17 насны 7,
- 18-24 насны 239,
- 25-29 насны 552,
- 30-34 насны 574,
- 35-39 насны 490,
- 50-54 насны 85,
- 55-с дээш насны 39 хүн үйлдсэн байна.

Дээрхи статистик мэдээнээс харахад гэр бүлийн хүчирхийллийг боловсрол мэргэжлийн түвшин, ажилтай эсэх хамаарахгүйгээр бүх насныхан үйлдэж байгаа нь түгшүүр төрүүлж байгаа юм.

Тэгвэл 2015 оны эхний 2 сарын байдлаар улсын хэмжээнд нийт 1.55.553 захиргааны зөрчил бүртгэгдсний 227 буюу 0.14 % нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 82.8 % нь согтуугаар гаргасан байна.

Монгол улсад үйлдэгдэж байгаа гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэх болсон шалтгааныг багцлан авч үзвэл:

1) 1990 оноос манай улс зах зээлийн нийгэмд шилжсэнээр улсын хэмжээнд ажилгүйчүүд бий болж, ажиллаж байгаагийнх нь цалин хангамж нь амьдралын баталгаа болж чадахгүйгээс ядуурал газар авсан. Ийнхүү иргэд ямар нэг хэмжээгээр байнгын бухимдалтай байх болсон холбоотойгоор архидалт, хүчирхийлэл үйлдэх болсон төдийгүй өрх гэр салах, орлого багатай байх зэргээс шалтгаалж хүүхдүүд сургууль завсардах, гуйланчлал, тэнүүчлэл, биеэ үнэлэх, гэмт хэрэг үйлдэх болон гуйлга гуйхийг тулган шаардаж дарамтлах, бэлгийн хүчирхийллийн хохирогч болох, өрх толгойлсон эмэгтэйчүүд олширох зэргээр монголын гэр бүлийн амьдралын хэв маяг, харилцааны соёлд сөргөөр нөлөөлж байна.⁵

Хүчирхийллээс үүдэлтэй гэмт хэргүүд дундаас гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчид нь эхнэр, ээж, аав, найз охин, эгч дүү, үр хүүхдийнхээ эрүүл мэнд, бие мах бодид халдан

⁵Ж.Алтанцэцэг. Гэр бүлийн харилцааны уламжлал, шинэчлэлийн асуудал //Илтгэл, судалгааны эмхтгэл-1. ХЭҮТ. 2005. 115 дахь тал

амь насыг нь зэрлэгээр хохироох явдал шүүхээр шийдвэрлэсэн гэмт хэргүүдийн 57.4 %-ийг эзэлж байгаа⁶ бол гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирогчдын талаас илүү хувь нь эхнэр, 10 орчим хувь нь эцэг, эх, 10 % үр хүүхэд нь байна.

2) Нийгмийн гишүүдийн эрх, эрх чөлөө сайн сайхан амьдралын баталгааг бүрдүүлж өгөх үүрэгтэй төр нь эдийн засгийн хямралыг даван туулахын тулд ажлын байрыг цомхтгох бодлого барьж байгаа нь цаг үеэ олоогүй алхам гэж үзэж байна. Манай улсын хэмжээнд 2014 онд гэр бүлийн хүчирхийллээс үүдэлтэйгээр үйлдэгдсэн нийт 1076гэмт хэрэг бүртгэгдэж, 1068 хүн холбогдон шалгагдсаны 512 буюу 47.6%-ийг тодорхой эрхэлсэн ажилгүй хүмүүс эзэлж байна. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч нь эрхэлсэн ажилгүйн улмаас бухимдаж, бухимдлаа архи ууж согтууран гэр бүлдээ агсам тавих байдлаар гаргаж, энэхүү үйлдэл нь даамжирсаар өөрийг нь хохирогч өрөөлийг гэмт хэрэгтэн болгоход ч хүргэж байна.Тухайлбал, гэр бүлийн хэрүүл, маргаанаас болж эхнэрийнхээ амийг хөнөөсөн хэргүүд цөөнгүй гарах болсныг бид хэвлэл мэдээллээс бараг л өдөр тутам сонсох болсон. Хорих ангид ял эдлэж байгаа эмэгтэйчүүдийн 30 % нь гэр бүлийн хүчирхийлэлд байнга өртөж, тэсвэр тэвчээр алдагдсны улмаас нөхрийнхээ болон хамтран амьдрагчийнхаа амь насыг хөнөөсөн хэрэгт 2-15 жилээс дээш хоригдох ял эдэлж байгаа ба тэд 3-5 хүүхэдтэй, орох оронгүй, ах дүү, төрөл садангүй, зарим хүүхэд нь өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэйн улмаас асрамжинд байх шаардлагатай, зарим нь өндөр настай аав ээжтэй зэрэг нь тэднийг сэтгэл зүйн байнгын дарамтад байлгасаар байна.

Энэ нь гэр бүлийн хүчирхийлэл гэх үзэгдэл үйлдэж байгаа болон өртөж байгаа хэн хэнийхээ амь биед аюултай гэдгийг харуулж байна.⁷

Эдгээр ял эдлэж байгаа эмэгтэйчүүдээс авсан судалгаагаар тэднээс хань ижил, ах дүү, найз нөхөд нь нүүр буруулсан, 35.3 % нь гэр бүл салсан, 27.7 % нь хүүхэд нь сургууль завсардсан, 16.8 % нь хүүхэд нь тэнэмэл амьдралтай болсон, 36.1 % нь орон гэргүй болсон, эд хөрөнгөө алдсан, 23.5 % нь аав, ээжийнх нь аль нэг нь нас барсан⁸ зэргээр гэр бүлд нь өөрчлөлт гарсан гэж байгаа нь тэдгээрийн ар гэр давхар хохирол амсдаг болохыг харуулж байна.

Ийнхүү гэр бүлийн хүчирхийлэл зөвхөн нэг хүний асуудал бус бүхэл бүтэн өрх гэрийн асуудал болдог байна.

Хорих ялтай байгаа эмэгтэйчүүд ял эдлээд гарахад очих орон гэргүй, ажил олдохгүй, хүмүүс үл ойлгох, үл итгэх, бичиг баримтын асуудалтай зэрэг бэрхшээл тугарахаас эмээж суудаг нь сэтгэл зүйн давхар дарамт эдэлж суугаагийн илрэл юм.

Дээрхи 2 шалтгаан нь гэмт хэргийн гаралтанд үнэмлэхүй жин дарах болсныг 1980-1990 онд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо /30552/, 1990-2000 онд бүртгэгдсэн гэмт хэргийн /85101/ тоотой харьцуулахад 2.8 дахин өссөн байгаа баримтаас харж болно.⁹

⁷ Т.Мөнхдалай. Гэр бүл дэх хүчирхийлэл, эмэгтэйчүүдээс гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлөх нь //Шинжлэх ухаан, практикийн анхаарал татсан асуудлууд. Эрдэм шинжилгээний бичиг-23. Цагдаагийн Академи. 2010. 18 дахь тал

⁸ Гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэмт хэрэг үйлдэн ял эдлэж байгаа эмэгтэйчүүдийн байдал судалгаа. ХЗҮХ. 2013

⁹ ЦЕГ-ийн цахим мэдээллийн сан

3) Харин иргэдийн хувьд гэр бүлийн хүчирхийлэл гэж юуг хэлээд байгааг бүрэн ойлгоогүй эргэлзсээр л, хань ижлээ засарна, төлөвшинө гэж итгэн хүлээсээр. Зарим нэг нь гэр бүлийн нэр төрийг бодох, үр хүүдээ өнчрүүлэхгүй байх, очих аав ээж, ах дүү амраг садангүй, орон гэргүй байдал, өөрөө ажилгүй буюу амьжиргааны эх сурвалжгүй байдал нь тэднийг хүчирхийллийг тэсэн тэвчихэд хүргэж, гэмт хэргийг нуугдмал байхад хүргэж байхад нөгөө хэсэг нь нөхөр маань надад хайртайдаа ингэж байна гэж төөрөлдөх, хүчирхийлэгчийн “чамд хайртайдаа хардаж зодсонд уучлаарай” гэсэн үгэнд хууртан зовж шаналж явна.

Нэг гэрт болж буй хүчирхийлэл зөвхөн тэндээ үйлчилдэггүй, зодуулж байгаа хүүхэд, хүүхнүүдийн дууг сонсон суугаа хөршийнхний сэтгэл эмтэрч, энэ тухай сонсох аав, ээжийн зүрх зүсэгдэн давхар шаналж байдаг.

Тиймээс гэр бүлийн хүчирхийлэл нь хэн нэгний зовлон зүдгүүр бус нийтийн зовлон, зүдгүүр юм.

4) Эцгийн эрхт ёсны уламжлал өнөөдөр манай иргэдийн дунд байсаар байгаа учраас нөхөр нь эхнэрээ, эцэг эх нь үр хүүхдээ ямар нэгэн байдлаар зодож “хашраах”, “хүмүүжүүлэх” арга хэрэглэж ирсэн нь өнөө үед уламжлагдан иржээ. Ийм учраас гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэг гэж ойлгохгүй, байх ёстой, хэвийн үзэгдэл гэсэн үзэл, хандлага гэр бүлийн дотор давамгайлж байна. Энэ хэвшмэл буруу ойлголт, хандлага нь хүчирхийлэл оршин тогтнох нэг үндсэн шалтгаан болж байна.

Хэдийгээр гэр бүл болгонд ахуйн шинж чанартай янз бүрийн маргаан зөрчил байдаг ч тэр бүхнийг гэр бүлийн хүчирхийлэл гэж үздэггүй. Харин гэр бүлийн гишүүдийн хэн нэг нь өөрийн эрх мэдлийг тогтоох зорилгоор ойр дотны хүмүүсийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг үл ойшоон тэдний эсрэг хүч хэрэглэдэгээрээ гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг нь ахуйн шинжтэй маргаан зөрчилөөс хүчирхийлэл ялгагдана.¹⁰ Бидэнд уламжлагдан ирсэн гэр бүлийн хүмүүжүүлэх арга, гэр бүлийн хүчирхийлэл 2 нь өөр хоорондоо ялгаатай бөгөөд өөрөөр хэлбэл эцэг эхийн зүгээс хүүхдээ хааяа гар хүрч сургаал айлдах нь аливаа зүйлд сургах зорилгыг агуулдаг бол гэр бүлийн хүчирхийлэл нь бусдыгаа өөрийн эрхшээлд оруулах, хараат байлгах зорилгоор байнгын шинжтэй тодорхой үйлдлийг хийдэг онцлогтой.

Эндээс харахад дээр үйлдлүүд нь өөр хоорондоо давтамж болон зорилгоороо ялгаатай байна.

5) Манай орны нэг өвөрмөц онцлог болох эдийн засгийн боломж нөхцөлтэй холбоотойгоор дийлэнх гэр бүлүүд эцэг, эхтэйгээ, хадмуудтайгаа нэг гэрт хамтран амьдардаг. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүчирхийлэгч нөхрөөс салаад очих өөрийн гэсэн гэр оронгүй байдал нь гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг гэмт этгээдтэй хүссэн, хүсээгүй эвлэрэх, гэмт этгээд хохирлоо барагдуулахгүй байх үндсэн нөхцөл болж байгаа ба төрөөс тэдний хохиролыг барагдуулах, нөхөн олговор өгөх эдийн засгийн боломжгүй чадавхгүй байдал болон энэ талаар санаа тавьж бодлого боловсруулахгүй байгаа зэрэг нь хохирогч хохирогчоороо л үлдэх нөхцлийг бүрдүүлж

¹⁰ Т.Оюунчимэг. Гэр бүлийн хүчирхийлэл. Лекц. 2014.

байгаа төдийгүй Үндсэн хуульд заасан аюулгүй орчинд амьдрах, халдашгүй дархан байх эрх зөрчигдөж байгаа билээ.

Өнөөдөр гэртээ болон оронд эхнэр, хүүхдээ зодож байхад хэн ч гарч ирж салгадаггүй, гудамжинд олны нүдний өмнө эхнэрээ зодож үсдэн чирч шороотой хутгах явдал жирийн үзэгдэл болсон төдийгүй тэр үйдлийг харсан хэн нэгэн туслахаар гар сунгах нь ч ховор болжээ. Энэ нь зодож хүчирхийлж байгаа нь ч түүнийг харж зогсоо нь ч ёс суртахуун, өрөвдөх хайрлах сэтгэлгүй болсны илрэл юм.

Энэ эцэг эхийн хайраар дутсаных уу? эсхүл төр засгийн халамж дутсан уу? гэдгийг бодуштай.

6) Төрийн болон төрийн бус байгууллагуудын зүгээс гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан нөхцлийг судлаад эмэгтэйчүүд гэр бүлдээ өндөр хариуцлага хүлээдэг боловч тэр нь гэр бүлдээ ч, нийгэмд ч үнэлэгддэггүйтэй холбоотойгоор гэр бүлийн хүчирхийлэлд өртөх, ихэнхи тохиолдолд хүчирхийллийг эрүүл мэнд, амь насаараа дэнчин тавьж тэвчих, альтернатив сонголт нь эдийн засгийн хүнд байдал бүхий гэр оронгүй, ажил төрөлгүй байх нөхцөл хүлээж байдаг¹¹ гэж тэмдэглэсэн нь бодит үнэн юм.

Улсын хэмжээний гэр бүл цуцлалтыг судлан үзэхэд үндсэн шалтгаан нь гэр бүлийн таагүй харилцаа буюу хүчирхийллийн улмаас салахаас өөр сонголтгүй болсонтой холбоотой байна. Ийнхүү өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоо ч өссөөр байна.

Шүүхээр гэр бүл цуцлуусан нийт хэргийн 58.8 % нь хүчирхийллээс үүдэлтэй, халамжийн болон асрамжийн төвд байгаа хүүхдүүдийн 22 % нь гэр бүлийн хүчирхийллээс дайжин орон гэрээ орхисон, ял эдлэж хүүхдүүдийн 22 % нь гэр бүлийн таагүй уур амьсгал, хүчирхийллээс болон гэмт хэрэг үйлдсэн¹² гэсэн тоо баримт ч байгаа юм. ЦЕГ-ын харьяа хаяг тогтоох төвд эцэг, эх нь салсан, эсхүл хойт эцэг, эхтэйгээ амьдардаг, өргөмөл, бүтэн болон хагас өнчин, төөрсөн, хаягдсан, тэнэмэл хэмээх тодотголтой хүүхдүүд байдаг ба тэд тэнэх болсон шалтгааны 50%-ийг гэр бүлийнхэн зодож хүчирхийлдэгээс¹³ болсон гэж хариулсан байна.

7) Хүчингийн гэмт хэргийн 64 хувь нь гэр бүлийн хүрээнд буюу ураг төрлийн холбоотой хүмүүс үйлдсэн, хохирогчдын 60 % нь бага болон өсвөр насны охид байдаг¹⁴ бол Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн хамгаалах байранд байрлаж байсан 110 эмэгтэйн 21 % нь нөхрийнхээ бэлгийн хүчирхийлэлд давхар өртөг, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн 39 % нь бэлгийн дарамт хүчирхийлэлд өртөг байна.¹⁵

Энэхүү хүчирхийлэл нь өргөн тархсан ч ихэнхдээ мэдээлэгддэггүй хэрэг бөгөөд ихэвчлэн ураг төрлийн холбоотой хүмүүсийн хооронд гардагаас гэр бүлийн нэр төрийг бодох, бусдаас ичих болон бага насны хүүхдийг, өөрөөр хэлбэл 14 нас хүрээгүй хүүхдийг

¹¹ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга зам. Гарын авлага. 2003. 14, 16 дахь тал

¹² Г.Бямбадорж. Гэр бүлийн хүчирхийлэл, түүнтэй тэмцэхэд анхаарах зарим асуудал //ГЯТА онол, арга зүйн улирал тутмын сэтгүүл. 2013. № 3 (45). 35 дахь тал

¹³ О.Отгонтуяа, О.Амарсайхан. Монгол улсын гэр бүлийн хууль, түүний хэрэгжилт. 2009. 33 дахь тал

¹⁴ П.Нарантуяа. Монгол дахь гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох эмэгтэйчүүдийн хөдөлгөөн //Илтгэл, судалгааны эмхтгэл-1. ХЭҮТ. 2005. 69 дэх тал

¹⁵ Жендерээс үүдэлтэй хүчирхийлэл Монголд. Судалгааны тайлан. Нийгмийн ажлын хөгжил төв. 2011. 30 дахь тал

хүчиндсэн бол 15-25 жил хүртэл хугацаагаар хорих буюу цаазаар авах ял шийтгэхээр Эрүүгийн хуульд заасан байдагтай холбоотойгоор аав, ахан дүүсийг цаазлуулахаас болгоомжлон хэргийг нуун дарагдуулах, насанд хүрээгүй хүүхдийн эрх ашгийг гаргуунд гаргадаг явдал байсаар байна.

Энэ байдал нь нэг талаар хүчингийн гэмт хэрэг үйлдэгчийг өөгшүүлж, гэмт хэрэг олон турш далд хэлбэрээр үргэлжлэх нөхцлийг бүрдүүлж байна.

8) Судалгаанаас харахад гэр бүлийн хүчирхийлэлд өртсний улмаас хуулийн байгууллагад хандсан иргэдийн тоо, гэр бүлийн хүчирхийллийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагад хандсан иргэдийн тооноос 4-5 дахин бага байна.

Сүүлийн 4 жилийн байдлаар гэр бүлийн хүчирхийллийн асуудлаар Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн нэг цэгийн үйлчилгээний төвөөр 277,¹⁶ Гэмтэл согог судлалын үндэсний төвөөр 955,¹⁷ нийслэлийн Сүхбаатар дүүргийн нэг цэгийн үйлчилгээний төвөөр 435,¹⁸ Хүчирхийллийн эсрэг үндэсний төвөөр 4334 хүн тус тус үйлчлүүлсний 76 хувь нь эмэгтэйчүүд, 24 хувь нь хүүхэд байна.

Хуулийн байгууллагад төдийлэн хандахгүй байгаа нь хүчирхийлэл үйлдэгчийн дарамт шахалтаас айх, өөрийн болон гэр бүлийн нэр төрөө бодох, нийгэм дэх хохирогчийг буруутгах хандлага, хууль эрх зүйн таагүй орчин зэрэг хүчин зүйлтэй холбоотой юм. Тухайлбал, хуулийн байгууллагад хандахад “гэр бүлийн дотоод асуудал” хэмээн гомдол, мэдээллийг хүлээн авдаггүй, хүлээн авсан ч “хүчирхийлэлд өртсөн нь хангалттай нотлогдоогүй” гэх үндэслэлээр эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах явдал түгээмэл байна. Хүчирхийлэлээс үүдэлтэй гэмт хэргүүдийг судлан үзэхэд 50 % нь хэрэгсэхгүй болсон байгаа нь нэг талаас энэ хохирогчийн гомдлыг харгалзахгүйгээр хэргийг шийдвэрлэх нөхцөл бүрээгүй нөгөө талаас хуулийн байгууллагын цаг, ажлыг үр ашиггүй үрэгдэхэд хүргэдэг “эвлэрдэг” хор уршгийг дагуултай холбоотой байна.

Өнөөгийн практикт гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчдэд Захиргааны хариуцлагын тухай хуулиар хариуцлага тооцохдоо “архидан согтуурсан, бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан” гэх хуулийн заалтыг үндэслэн эрүүлжүүлэх, баривчлах, торгох зэрэг захиргааны арга хэмжээ авч байгаа нь хохирогчийг хамгаалах биш, тэднийг давхар хохироож байна. Учир нь ихэнх тохиолдолд хүчирхийлэл үйлдэгчид ногдуулж буй торгуулийг гэр бүлийнхэн нь төлөх, хүчирхийлэгчийг эрүүлжүүлж, баривчилснаар хохирогчид улам өширхөх, дарамт шахалт учруулах, хүчирхийлэл улам даамжрах нөхцлийг бий болгож байна.

9) Эцэст нь иргэдэд үйлчилдэг үйлчилгээний байгууллагынхны сэтгэлгээг өөрчлөх шаардлагатай байна. Учир нь гэр бүлийн хүчирхийллийн хохирогчтой учрах хууль, шүүхийн байгууллагынхан нэгдүгээрт гэр бүлийн хүчирхийллийг “гэр бүлийн дотоод асуудал” гэж үзэх уламжлалт хандлагаасаа салахгүй байгаагаас, хоёрт “хохирогчийг гэмт этгээдийн гэм бурууг тогтоох хэрэгсэл” болгодог уламжлалт хандлагаас салж чадахгүй

¹⁶ Шүүхийн Шинжилгээний Үндэсний Хүрээлэнгийн нэг цэгийн үйлчилгээний тайлан. 2011-2013

¹⁷ Гэмтэл Согог Судлалын Үндэсний төвөөс ирүүлсэн мэдээлэл. 2013

¹⁸ Нийслэлийн Сүхбаатар дүүргийн нэг цэгийн үйлчилгээний тайлан. 2013

байгаатай холбоотойгоор иргэдэд хэрэгцээтэй цагт нь үйлчилгээ үзүүлж амь насыг нь хамгаалж чадахгүй байна.

Дэвшүүлсэн санал

1. Гэр бүлийн хүчирхийллийн тухай ойлголтыг нийт иргэдэд ойлгуулах мэдээлэл хүргэх
2. Гэр бүлийн хүчирхийллээс үүдэлтэй гэмт хэргийн статистик тоо бүртгэлийг бодитой болгож тухайн гэмт хэргийн нөхцөл байдлыг тогтоож урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах
3. Энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн байцаах онцлогыг тодорхой болгож арга зүйг сайжруулах шаардлагатай байгаа гэж бид үзлээ.